



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 ²¹ он ¹⁰ дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ХЭТ/эхгү

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх намрын ургац хураалт болон хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт⁶ хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000021513460

НАМРЫН УРГАЦ ХУРААЛТ БОЛОН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ

Нэг. 2021 оны ургац хураалтын ажлын талаар:

1.1. Урьдчилсан баланс, ургац хураалтын явцын талаар:

Энэ онд улсын хэмжээнд 420.2 мянган га-д үр тариа, үүнээс 389.4 мянган га-д улаанбуудай, 19.8 мянган га-д төмс, 9.9 мянган га-д хүнсний ногоо, 100.4 мянган га-д тосны ургамал, 100.0 мянган га-д тэжээлийн ургамал, 4.7 мянган га-д жимс, жимсгэнэ, нийт 655.0 мянган га-д тариалалт хийсэн.

Ургацын урьдчилсан балансаар 594.1 мянган тонн үр тариа, үүнээс 559.2 мянган тонн улаанбуудай, 198.8 мянган тонн төмс, 117.0 мянган тонн хүнсний ногоо, 64.3 мянган тонн тосны ургамал, 203.3 мянган тонн малын тэжээлийн ургамал тус тус хураан авах боломжтой гэсэн төлөв гарсан. Урьдчилсан балансаас харахад улаанбуудай, төмсний хэрэгцээг 100 хувь, хүнсний ногооны 60 хувийг дотоодын ургацаас хангах боломж бүрдэхээр байна.

Байгалийн давагдашгүй хүчин зүйл болох үргэлжилсэн их бороо, үер, хүчтэй мөндөр, хүйтрэлт, зарим бүс нутагт тохиолдсон нарны хэт халалтын улмаас 12.2 мянган га талбайн ургац болц дутуугаас ногоон тэжээлд шилжиж, 5.3 мянган га талбай ганд өртөж, 1.3 мянга га талбайн ургац мөндөрт цохигдсон бол төмс, хүнсний ногооны 961 га талбайн ургац үерт өртсөн.

Ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд үр дүнтэй, шуурхай зохион байгуулах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд ургацын төв штабыг ажиллуулж, холбогдох төрийн байгууллагуудын оролцоо, ажлын уялдаа холбоог ханган ажиллаж байна.

Мөн тариалангийн бүсүүдэд явуулын судалгааг гүйцэтгэн, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх зөвлөмж, ургацыг хаягдалгүй хураах технологийг боловсруулж тариаланчдад хүргэснээс гадна ургац хураалтын ажлыг шуурхай зохион байгуулахад орон нутгийн удирдлагуудад чиглэл өгсөн болно.

Тухайлбал, тариаланчдаас намрын ургац хураалтын ажилд 8.0 мянга гаруй оюутан, сонсогчид, цэргийн алба хаагчдыг авч ажиллуулах хүсэлт, захиалга ирүүлсэн бөгөөд Засгийн газрын 235 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажиллаж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд холбогдох яамд Монголын залуучуудын холбоо, Залуучуудын хөдөлмөрийн төв биржтэй хамтран “Алтан намар” дэд төслийг хэрэгжүүлж, ургац хураалтын ажилд оролцуулснаар өнөөдрийн байдлаар ургац хураалтад 1.7 мянган цэрэг, 1.9 мянган оюутан, 7.4 мянган халамжийн болон гэрээт ажилтан, нийт 11.1 мянган хүн хөдөлмөрийн түр гэрээгээр ажиллаж байна.

Ургац хураалтын ажилд нийт 1041 комбайн, 587 ширхэг жатка, 220 гаруй үтрэм, 389 ширхэг үр тариа цэвэрлэх машин, 316 ширхэг үр тариа ачигч машин, 72 ширхэг төмс хураах комбайн, 417 ширхэг төмс ухагч, 69 ширхэг төмс, хүнсний ногоог ангилах сортлох машин ажиллаж байна.

Ургац хураалт 10 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 55.7 мянган га талбайг ангилан хадаж, 106.4 мянган га-гаас 154.6 мянган тонн үр тариа, үүнээс 99.7 мянган га-гаас 145.2 мянган тонн улаанбуудай, 13.9 мянган га-гаас 128.4 мянган тонн төмс, 6.1 мянган га-гаас 72.6 мянган тонн хүнсний ногоо, 22.6 мянган га-гаас 64.5 мянган тонн тэжээлийн ургамал, 22.6 мянган га-гаас 13.7 мянган тонн тосны ургамал тус тус хураан авснаар үр тарианы хураалт 26.4 хувьтай, төмс, хүнсний ногооны хураалт 65.6-69.9 хувийн явцтай байна.

Улсын хэмжээнд үр тариа хадгалах 523.0 мянган тоннын багтаамжтай төмөр бетон элеватор байгаагаас Хөдөө аж ахуйг дэмжих санд 182.0 мянган тонн, хувийн хэвшилд 341.0 мянган тонн нь ашиглагдаж байгаа бөгөөд элеваторуудын ариутгал, засвар үйлчилгээ хийгдэж, намрын ургац хураалтаас буудай хүлээн авах арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Улаанбаатар хотод шинэ ургацын төмс, хүнсний ногоогоор хангах, тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор 9 дүгээр сарын 16-23-ны өдрүүдэд “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Алтан намар” үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа.

Тус арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран 9 дүүргийн 24 байршилд томоохон хэмжээний төвлөрсөн цэг байгуулан ажиллуулж байгаагийн зэрэгцээ хүнсний ногоо тариалагчдыг дэмжих зорилгоор дүүрэг, хороо, хорооллын дунд төмс, хүнсний ногооны борлуулалтыг чөлөөтэй явуулах боломжийг бүрдүүлсэн болно.

1.2. Хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар:

“Ургац хураалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 235 дугаар тогтоолын хүрээнд ургац хураалтад ажиллах хүн, хүчийг нэмэгдүүлэх, ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн ажилд нэн шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бараа материалыг улсын хилээр шуурхай нэвтрүүлэх, тариалангийн бүсийн зам, гүүрийн эвдрэл, гэмтлийг шалган тогтоож, засварын ажлыг цаг алдалгүй хийх, ургац тээвэрлэлтийг авто болон төмөр замын мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авахыг холбогдох байгууллагуудад даалгасан бөгөөд ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр дараах ажлыг зохион байгууллаа. Үүнд:

- Онцгой дэглэм тогтоосон энэ үед ажлын байрыг хадгалах, үндсэн нэр төрлийн таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн ачааллыг хөнгөлөх, хаврын тариалалтад бодитой дэмжлэг үзүүлэх, цаашид тариалангийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “Тариалалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 142 дугаар тогтоолыг батлан гаргаж, импортоор нийлүүлэгдэж байгаа улаанбуудайн үрийн үнийг 30 хувиар, тэжээлийн таримал болон төмсний үр, нийлэг хальсан хучлагын үнийг 50 хувиар, хүнсний ногоо, хүлэмжийн таримлын үрийн үнийг 80 хувиар тус тус хөнгөлж олгохоор шийдвэрлэсний дагуу хэрэгжилтийг зохион байгуулсан;
- Хаврын тариалалтад зориулан импортын 10.2 мянган тонн, Хөдөө аж ахуйг дэмжих санд дотоодын ургацаас бүрдүүлсэн 5.0 мянган тонн, нийтдээ 15.2 мянган тонн улаанбуудайн үрийн нөөц бүрдүүлж, улмаар хүсэлт гаргасан 390 гаруй аж ахуйн нэгж, иргэдэд 12.5 мянган тонн улаанбуудайн үр, 43.3 тонн ургамал хамгааллын бодис, 330 тонн нийлмэл болон гумины бордоог 30 хувийн урьдчилгаатай, 347.9 мянган литр шатахууныг 50 хувийн

урьдчилгаатай тус тус зээлээр олгож, дэмжлэг үзүүлснээр төлөвлөсөн хэмжээнд тариалалт хийх боломжийг бүрдүүлсэн;

- “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Өрхийн тариалан” хөдөлгөөн өрнүүлж, тариалах талбай, хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлэн, хангамжийг тогтворжуулах зорилгоор улсын төсвийн 1.9 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 10 нэр төрлийн 176.2 тонн ил талбайн болон хүлэмжийн ногооны үр импортоор нийлүүлсэн. Улмаар Засгийн газрын 142 дугаар тогтоолын дагуу үнийг 80 хувиар хөнгөлж, аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжуулан тариалан бүхий иргэн, аж ахуйн нэгжүүдэд олгосон бөгөөд энэхүү хөнгөлөлт, дэмжлэгт хот, хөдөөгийн 10 орчим мянган өрх хамрагдсан байна;
- Монгол Улсын Засгийн газраас баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд арилжааны банкны эх үүсвэрээс 100.0 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсний дагуу 10 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар Төрийн банк, Хаан банк, Хас банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Капитрон банкаар дамжуулан тариалан бүхий 939 иргэн, аж ахуйн нэгжийн зээлийн хүсэлтийг хүлээн авснаас 548 иргэн, аж ахуйн нэгжид 35.6 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна;
- Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дэмжих” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн тариаланд ашиглах усалгааны тоног төхөөрөмж, бага оврын бороожуулагч, дуслын усалгааны системийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгох ажлыг зохион байгуулснаар нийт 58 аж ахуйн нэгж, 22 иргэнд 165 ширхэг тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож, усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 7.0 мянган га-аар нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн;
- Төв суурин газрын иргэдийн хүнсний ногооны хангамжийг сайжруулах чиглэлээр улсын төсвийн 300.0 сая төгрөгийн санхүүжилтээр 32 м.кв талбай бүхий 83 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмж нийлүүлж, хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, иргэдэд 30 хувийн урьдчилгаатай зээлээр олгох арга хэмжээг хэрэгжүүллээ;
- Газар тариалангийн гаралтай бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зорилтын хүрээнд тариалангийн үйлдвэрлэлд 2021 онд ашиглаж болох химийн бордоо, ургамал хамгааллын бодисын нэр төрөл, тоо хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан бөгөөд 2021 оны хаврын тариалалтад зориулан тусгай зөвшөөрөл бүхий 14 аж ахуйн нэгжид 1300 гаруй тонн ургамал хамгааллын бодис импортлох зөвшөөрлийг олгож, газар тариалангийн үйлдвэрлэлд нийлүүлсэн;
- Оросын Холбооны Улсаас үр тариа хураах өндөр хүчин чадлын 50 гаруй комбайныг арилжааны банкны санхүү, түрээсийн үйлчилгээгээр нийлүүлсний зэрэгцээ Беларусь Улсын Засгийн газрын 4.5 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр ногоон тэжээл бэлтгэх зориулалттай 60 иж бүрдэл, төмсний 30 иж бүрдэл, хүнсний ногооны 20 иж бүрдэл техник, тоног төхөөрөмжийг ургац хураалтаас өмнө нийлүүлж, хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээлээр олгосон;
- “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын санхүүжилтээр “Чацарганын нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэх, гадаад зах зээл, маркетингийг сайжруулах” туршилтын төсөл хэрэгжүүлэхээр тохиролцож, Монгол чацарганын шинж чанарыг Япон Улсад судлуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр ажиллаж эхлээд байна.

Хоёр. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар:

2.1. Монгол орны зуншлага, бэлчээрийн даацын талаар:

Ус, цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгээс гаргасан 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн зуншлагын байдлын мэдээгээр нийт нутаг дэвсгэрийн 80 гаруй хувьд тунадас олон жилийн дунджийн орчим буюу түүнээс дээш хэмжээтэй унаж, зуншлага сайн байсан.

Харин 2021 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн бэлчээрийн даацын мэдээгээр нийт нутгийн 42.1 хувь нь бэлчээрийн нөөцтэй, 24.6 хувь нь бэлчээр хүрэлцээтэй, 25.0 хувийн даац 1-3 дахин хэтэрсэн, 3.6 хувийн даац 3-5 дахин хэтэрсэн, 4.7 хувийн даац маш их буюу олон дахин хэтэрсэн байгаа гэсэн дүн гарсан.

Аймгийн дүнгээр авч үзвэл Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Өвөрхангай, Архангай, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь, Сүхбаатар аймгуудын зарим сумд, багийн нутгаар бэлчээрийн даац хэтэрч гарсан бол олон дахин хэтэрч гарсан сумдад Баян-Өлгий аймгийн Булган, Дундговь аймгийн Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумд орж байна.

Дээрх мэдээллээс дүгнэж үзэхэд 2021 онд зуншлага сайн байсан хэдий ч нийт бэлчээрийн 66.7 хувь нь малдаа хүрэлцэх хэмжээний тэжээлийн нөөцтэй, 33.3 хувь нь тэжээлээр хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл, нийт бэлчээрийн гуравны нэгд мал сүргийн нягтрал их байгаа нь эдгээр газруудад бэлчээрийн даац хэтэрсэн төлөв байдалтай байна.

2.2. Өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар:

Мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд “Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 221 дүгээр тогтоол гарсан. Тогтоолын хүрээнд хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг байгалийн болзошгүй гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлыг орон нутгийн төр, захиргааны байгууллага, малчид, иргэд, аж ахуйн нэгжийн түвшинд сайтар ханган биелүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Улсын хэмжээнд 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах хүрээнд нийт 44900 тонн өвс, 2900 тонн ногоон тэжээл, 14860 тонн тэжээл тус тус бэлтгэхээр төлөвлөсөн. Үүнээс аймгуудын аюулгүй нөөцөд нийт 2450 тонн өвс, 2900 тонн ногоон тэжээл, 2190 тонн тэжээл, сум, дүүргийн аюулгүйн нөөцөд нийт 39010 тонн өвс, 12720 тонн тэжээл, малчдын түвшинд 1.23 сая тонн өвс, 1.6 мянган тонн сүрэл, 13 мянган тонн ногоон тэжээл, 95.9 мянган тонн үйлдвэрийн тэжээл, 98 мянган тонн гар тэжээл, 0.9 мянган тонн дарш, 132 мянган тонн хужир шүү бэлтгэхээр төлөвлөсөн.

2021 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн байдлаар хадлан бэлтгэлд 4712 дугуйт трактор, үүнээс бага оврын трактор 3544, хадуур 1967, тармуур 2910, хаман боогч 654, морин хадуур 694, морин тармуур 863, чиргүүл 1639, 79 нуруулдагч техник ашиглаж байна.

Малчдын түвшинд өвс, тэжээлийн бэлтгэл ажлын явц 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 791.9 мянган тонн өвс, 22.1 мянган тонн ногоон тэжээл, 1.8 мянган тонн үйлдвэрийн тэжээл, 23.9 мянган тонн гар тэжээл, 1.3 мянган тонн дарш, 31.5 мянган тонн хужир, шүү тус тус бэлтгэж, гүйцэтгэл 52.7 хувьтай байна.

Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын Аргалант, Ачит нуур, Багахайрхан, Баян нуур, Малах, Чилэн, Чойбалсан, Хөх дэл, Хэрлэнбаян-Улаан отрын бүс нутгийн бэлчээрийн даац тодорхойлох ажлыг 8 дугаар сард зохион байгуулахад 2021-2022 оны өвөл нийт хонин толгойд шилжүүлснээр 854 мянган толгой малыг өвөлжүүлэх бэлчээрийн даацтай гэсэн дүн гарсан. Дээрх отрын бүс нутгуудад 19 аймгийн 70 сумын 1850 малчин өрхийн малыг отроор өвөлжүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

2.3. Хөдөө аж ахуйн салбарын бэлтгэл хангах хүрээнд хэрэгжүүлж байгаа ажлын талаар:

Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг байгалийн болзошгүй гамшиг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

- Монгол Улсын Шадар сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан Албан даалгавар гаргаж, Аймгийн Засаг дарга нарт хүргүүлснээс гадна Засгийн газрын тогтоол, албан даалгаврын хэрэгжилтийг хангах талаар бүх аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нартай цахим уулзалт зохион байгуулж, үүрэг, чиглэл өгсөн;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Мал аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, зохион байгуулах тухай зөвлөмж гаргаж аймаг, орон нутагт хүргүүлсэн;
- Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь аймгуудыг хамруулан микробиологийн аргаар 2021 оны 4 дүгээр сарын 20-оос 5 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 86 мянган га бэлчээрийн ургамлыг мэрэгч амьтны хөнөөлөөс хамгаалан мал аж ахуйн үйлдвэрлэлд хэвийн ашиглах боломжийг бүрдүүлсэн. Мөн үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээний намрын ажлыг 9-11 дүгээр сард 9 аймаг, аймаг дундын отрын бүс нутгийн 400 орчим мянган га бэлчээрийн талбайд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэ ажлын үр дүнд өвөл, хаврын улиралд ашиглах бэлчээрийн хэмжээг 400 орчим мянган га талбайгаар нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ;
- Өвс, тэжээлийн хангамжийг тогтвортой байлгах зорилгоор 2021 оны 9 дүгээр сарын 1-ээс 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд өвс, тэжээл, хивэгний экспортыг зогсоох шийдвэрийг Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ажлын хэсэг 2021 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар 19 аймгийн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл, бэлчээрийн ургамлын байдал, аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн бүрдүүлэлт, отор нүүдлийн зохицуулалт, суурин газрын хүн амын өвөл, хаврын махны нөөц бүрдүүлэх ажлын явцтай газар дээр нь танилцаж, бүрдүүлэлт дутуу байгаа ажлын гүйцэтгэлийг 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор хангаж, биелэлтийг ирүүлэх тухай зөвлөмж, чиглэл өгсөн байна;

- Манай орны хэмжээнд гоц халдварт вирусын гаралтай өвчний гаралт нэмэгдэж байна. Гоц халдварт шүлхий, хонины цэцэг, бог малын мялзан, үхрийн арьс товруутах өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хууль тогтоомж, заавар журмын хүрээнд хэрэгжүүлж байна. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 2021 оны хаврын дархлаажуулалтад эхний ээлжийн 5.0 сая тун вакциныг 6-8 дугаар саруудад Улаанбаатар хот болон Дундговь, Төв, Өмнөговь, Хэнтий, Сүхбаатар, Говьсүмбэр, Дорноговь аймгуудын 9.8 сая толгой мэдрэмтгий малд, мөн Баянхонгор, Баян-Өлгий, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Ховд аймгийн шүлхий өвчин гарсан сумдын 8.9 сая толгой малыг хамруулахаар вакцинжуулалтын арга хэмжээг зохион байгуулж, 2021 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар 7.7 сая толгой малыг дархлаажуулж, 86.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Түүнчлэн Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Дорноговь аймагт бэлчээрийн ургамлын ургалт муу, өвсний гарц сайнгүй байгаатай холбогдуулан малчид цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээлээ бэлтгэх, хашаа хороогоо засварлах, дулаалах, өтөг бууцаа засах зэрэг ажлыг сайтар зохион байгуулахад онцгой анхаарал хандуулж байна.

Гурав. Нөөцийн мах бэлтгэлийн явцын талаар

Монгол Улсын Засгийн газраас баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд Засгийн газрын 216 дугаар тогтоолоор 2021-2022 оны өвөл, хаврын улирлын махны нөөц бүрдүүлэхэд зориулан 100.0 тэрбум төгрөгийг баталсан бөгөөд нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх ажлыг 17 аж ахуйн нэгж гүйцэтгэж байна.

2021 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар 1600.0 тн мах бэлтгээд байна. Цаашид нэг сарын хугацаанд нийт бэлтгэх махны 60 хувиас доошгүйг бэлтгэж нөөцлөхөөр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж байна.

Аймгийн төв, суурин газрын хүн амын 2022 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан нийт 5.5 мянган тонн мах бэлтгэх үүрэг, чиглэлийг хүргэн, бэлтгэл ажлыг хангаж байна.

Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр ханган, тогтоол, шийдвэрийн биелэлтэд тогтмол хяналт тавин ажиллаж байгаа болно.

-----oOo-----